УБЕХ маягт № БТ-2

# ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР № 00000804

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: | 2022-02-11 | Дансны дугаар | Дүн /тоогоор/ |
| Төлөгч: | **Диспетчерийн үндэсний төв ХХК** | Дебит | **22,500,000.00** |
| Төлөгчийн: | **Худалдаа Хөгжлийн Банк** | **406002860** | |
| Хүлээн авагч: | **Ганболд Тогтоол** | Кредит | |
| Хүлээн авагчийн: | **ХААН Банк** | **5749380096** | |
| Мөнгөний дүн тоогоор (үсгээр) | **22,500,000.00** | | . . . . хоногийн . . . хувийн торгууль . . . . . . төгрөг . . . . мөнгө |
| **( Хорин хоёр сая таван зуун мянган төгрөг 00 мөнгө )** | | | |
| Барааг хүлээн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн: | | | Дүн (торгуулийн хамт) |
| Дагалдах баримтын № | Огноо: **2022-02-11** | | **** |
| Төлбөрийн зориулалт (барааны болон ажил үйлчилгээний нэр) | | | Гүйлгээний утга (Төлбөрийн зориулалт) |
| **Д.Бат-Эрдэнэд орон сууцны дэмжлэг олгосон** | | | |

Тамга

УЛААНБААТАР ХОТ
ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХХК
АТА4807 ☏ 2699877
9020110314

Гүйцэтгэх захирал: . . . . . . . . . . . . . . . . . . . .

Ерөнхий нягтлан бодогч: . . . . . . . . . . . . . . . .

Банкинд гүйлгээ хийсэн

. . . . оны . . . сарын . . .

. . . . . . . . . . . . . . . .

(тэмдэг, гарын үсэг)

Теллер №04
2022-02-11

Төлөх хугацаа

Төлбөрийн зэлж

**ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 01 сарын 31 өдөр Дугаар Б/31 Улаанбаатар хот

Ажилтнуудад орон сууц худалдан авахад санхүүгийн дэмжлэг олгох, гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7, Компанийн захиргаа, ҮЭХ-ны хооронд байгуулсан 2021-2022 оны “Хамтын гэрээ”-ний 5.7 дахь заалт, Ажилтнуудад орон сууцны санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмын 2.1, 2.2, 2.3, 2.4 дэх заалтууд, Нэмэлт ажил, үйлчилгээ зохицуулах журамын 5.4, захирлын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажилтнуудад орон сууцны санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмын нөхцөл шаардлагыг хангаж орон сууц худалдан авахад нь санхүүгийн дэмжлэг болгон тус бүр 25,000,000 (хорин таван сая) төгрөг, орон сууцны нөхцөл сайжруулах дэмжлэг болгон тус бүр 15,000,000 (арван таван сая) төгрөгийг олгох ажилтнуудыг нэгдүгээр хавсралтаар батлсугай.

2. Хавсралтад заагдсан ажилтнуудад олгох нийт 65,000,000 (жаран таван сая) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Санхүү эдийн засгийн албаны дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч (Т.Бямбажав)-т зөвшөөрсүгэй.

3. Орон сууц худалдан авахад санхүүгийн дэмжлэг авч буй ажилтнуудтай орон сууцны санхүүгийн дэмжлэг олгосон тухай гэрээ байгуулахыг Захиргаа удирдлагын албаны ахлах мэргэжилтэн (С.Намчиндорж)-д даалгасугай.

4. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын алба (Б.Биндэръяа)-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАЛЖИННЯМ

# АЖИЛТАНД ОРОН СУУЦНЫ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЭЭ

2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр №19/2022 Улаанбаатар хот

Энэ гэрээг нэг талаас Диспетчерийн үндэсний төв ТӨХХК /ДҮТ/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Г.Балжинням /цаашид “Компани” гэх/ нөгөө талаас тус компанийн Төв диспетчерийн албаны диспетчер инженер ажилтай Даваадорж овогтой Бат-Эрдэнэ РД: УЕ87091476 /цаашид “Ажилтан” гэх/, /хамтад нь Талууд гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 17-ний өдрийн 25 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн Б/31 тоот тушаалыг тус тус үндэслэн дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Монгол Улсын Иргэний тухай хуулийн 15 дугаар бүлэг буюу гэрээний эрх зүйн зохицуулалтыг үндэслэн энэ гэрээтэй холбоотой үүсэх Талуудын эрх, үүрэг, хариуцлагыг харилцан тохиролцоно.

1.2. Компанийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн №А/309 тоот тушаалын хавсратаар батлагдсан “Ажилтнуудад орон сууц худалдан авах, нөхцөл сайжруулахад санхүүгийн дэмжлэг олгох журам”-ын дагуу Компанийн захиргаанд Ажилтны гаргасан орон сууцны санхүүгийн дэмжлэг хүссэн өргөдлийг хэлэлцсэн Захирлын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хурлаас “Ажилтанд орон сууцны санхүүгийн дэмжлэг олгох”-оор шийдвэрлэсэн шийдвэр нь энэ гэрээний салшгүй хэсэг байна.

1.3. Ажилтны худалдан авсан орон сууцны Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг энэ гэрээнд хавсаргана.

## ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

2.1. Энэ гэрээний зорилго нь Компанийн зүгээс “Компанийн захиргаа, ҮЭХ-ны хооронд байгуулсан Хамтын гэрээ”-ний дагуу Ажилтанд орон сууцны санхүүгийн дэмжлэг өгөх, Ажилтан тогтвор суурьшилтай, хөдөлмөрийн өндөр бүтээмжтэй үргэлжүүлэн ажиллахтай холбогдох харилцааг зохицуулна.

2.2. Орон сууцны санхүүгийн дэмжлэг болгож нийт 25,000,000.00 төгрөг /ХХОАТ суутгаагүй дүн/-ийг Ажилтанд орон сууц /үл хөдлөх хөрөнгө/ худалдагч Т.Ганболдын Хаан банк дахь 5749380096 тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ. /Мөнгө шилжүүлсэн баримт нь гэрээний салшгүй хэсэг болно/.

2.3. Энэ гэрээ нь Ажилтанд орон сууцны санхүүгийн дэмжлэг олгосон өдрөөс эхлэн 8 /найм/ жилийн хугацаанд хүчинтэй байна.

## ГУРАВ. КОМПАНИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Компанийн Захирлын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн Ажилтанд орон сууцны санхүүгийн дэмжлэг олгохдоо “Ажилтнуудад орон сууц худалдан авах, нөхцөл сайжруулахад санхүүгийн дэмжлэг олгох журам”-ын дагуу тухайн шийдвэр гарсан онд багтаан Ажилтны харилцах банкны дансанд шилжүүлсэн.

3.2. Компани нь хуульд өөрөөр заагаагүй бол Ажилтны хөдөлмөрийн гэрээнд орон сууцны санхүүгийн дэмжлэг өгсөн хугацааг нэмэлтээр оруулж болно.

3.3. Ажилтны худалдан авсан үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, мөнгөний баримт, өргөдөл, иргэний үнэмлэх болон бусад баримт бичгийн хуулбарыг энэ гэрээнд хавсаргана. Эдгээр баримт нь гэрээний салшгүй хэсэг байна.

3.4. Гэрээний хугацаанд Ажилтан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин болон бусад өвчний улмаас тахир дутуу болох, хөдөлмөрийн чадвараа удаан хугацаагаар алдсан болон нас барсан тохиолдолд энэ гэрээг хугацаанаас өмнө цуцлах бөгөөд гэрээг цуцалсан өдрөөс хойшхи үлдэгдэл хугацаанд хамаарах төлбөрийн тооцоог ажилтны гэр бүлд үлдээн төлүүлэх эсэх асуудлыг компанийн захиргаа, ҮЭХ-ны хамтарсан хурлаар шийдвэрлэнэ.

3.5. Компани нь энэ гэрээний 3.4-т зааснаас бусад тохиолдолд Ажилтны хөдөлмөрийн гэрээ ажилтны болон захиргааны санаачлагаар цуцлагдсан үндэслэлээр энэ гэрээ дуусгавар болсон тохиолдолд холбогдох журмын дагуу энэхүү гэрээний 2.3-т заасан хугацаанаас ажиллаагүй үлдсэн жилд ногдох төлбөрийг ажилтнаар төлүүлэх эрхтэй.

3.6. Ажилтан өөрийн зардлаар эрчим хүчний чиглэлээр урт болон богино хугацаагаар суралцахаар өргөдлөө гаргасан тохиолдолд Гүйцэтгэх захирал холбогдох шийдвэрийг гаргана.

## ДӨРӨВ. АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Ажилтан гэрээнд заасан холбогдох баримтыг бүрэн бүрдүүлж, орон сууцны санхүүгийн дэмжлэг авна.

4.2. Ажилтан нь өөрийн худалдан авсан орон сууцны гэрчилгээ, мөнгөний баримт, өргөдөл, иргэний үнэмлэх болон бусад баримт бичгийн хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн компанид хүлээлгэж өгнө.

4.3. Ажилтан нь гэрээнд заасан хугацаанд тогтвор, суурьшилтай, хөдөлмөрийн өндөр бүтээмжтэйгээр ажиллана.

4.4. Ажилтны санаачлагаар эсхүл ажилтан хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасан сахилгын ноцтой зөрчил гаргасны улмаас хөдөлмөрийн гэрээ цуцалсан тохиолдолд ажиллаагүй жилд ногдох төлбөрийг Компанид буцаан төлнө.

4.5. Үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой гуравдагч этгээдийн гомдол, эрх бүхий байгууллагын үндэслэл бүхий шийдвэр болон бусад маргаан, эрхийн зөрчил, бусад зөрчилтэй холбоотой хариуцлагыг Ажилтан бүрэн хариуцах үүрэгтэй.

## ТАВ. БУСАД

5.1. Энэ гэрээ нь Ажилтны өөрийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан хөдөлмөрийн гэрээг Захиргааны санаачлагаар цуцлахгүй байх баталгаа болохгүй.

5.2. Компани нь Ажилтны хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан өдөр үлдэгдэл төлбөрийг төлөх хугацааг тохиролцон тогтоож болно. Ажилтан тухайн хэлцэл, гэрээг байгуулахаас татгалзах хуульд заасан үндэслэлээс бусад шалтгаанаар татгалзахгүй болохоо баталгаажуулав. Татгалзах болсон хуулийн үндэслэлийг нотлох үүргийг Ажилтан бүрэн хүлээнэ.

5.3. Гэрээг хоёр хувь үйлдэж талууд гарын үсэг зурж, Компанийн тэмдгээр баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.

5.4. Гэрээг Талууд тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

## ЗУРГАА. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛГОХ

6.1. Энэ гэрээ дараах үндэслэлээр дуусгавар болно.

6.1.1. Энэ гэрээний хугацаа бүрэн дуусcанаар энэ гэрээ дуусгавар болно.

6.1.2. Ажилтны хөдөлмөрийн гэрээ цуцлагдсанаар энэ гэрээг хугацаанаас өмнө цуцлах тохиолдолд ажиллаагүй үлдсэн жилд ногдох төлбөрийг Ажилтан бүрэн төлж дуусcанаар гэрээ дуусгавар болно.

## ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1. Талууд энэ гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ зөрчсөн тохиолдолд харилцан зөвшилцөж шийдвэрлэх бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**:

**КОМПАНИЙГ ТӨЛӨӨЛЖ:**
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
_______________/Г.БАЛЖИННЯМ/
ЗУА-НЫ ДАРГА
_______________/Б.БИНДЭРЪЯА/
САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
_______________/Т.БЯМБАЖАВ/
ҮЭХ-НИЙ ДАРГА
_______________/Д.НАЦАГДОРЖ/
ХУУЛЬЧ
_______________/Б.АНХЗАЯА/
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
_______________/С.НАМЧИНДОРЖ/

**ХАЯГ:**
Монгол Улс, Улаанбаатар хот 17060 Хан-уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн Өргөн чөлөө Засгийн газрын XIV байр 4,5 давхар
Утас: 7004 1371, 91177701
Факс: 7004 3467
Мэйл хаяг: namchindorj.s@ndc.energy.mn

**АЖИЛТАН:**
ТӨВ ДИСПЕТЧЕРИЙН АЛБАНЫ ДИСПЕТЧЕР ИНЖЕНЕР
_______________/Д.БАТ-ЭРДЭНЭ/

**ХАЯГ:**
Монгол Улс, Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2-р хороо, 49 байр, 3 тоот
Утас: 99070687
Имэйл: baterdene.d@ndc.energy.mn

НИЙСЛЭЛИЙН ТОЙРГИЙН НОТАРИАТЧ Х.МАЯРАГУЛЬ

**ЗЭЭЛЭЭР ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

**/ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ/**

Бүртгэлийн дугаар 0235

2022 оны 02 сарын 07 өдөр 15 цаг 25 минут Улаанбаатар хот

Монгол Улсын Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1, 243 дугаар зүйлийн 243.1, 262 дугаар зүйлийн 262.1 дэх хэсгийг тус тус үндэслэн:
**Худалдагч:** Улаанбаатар, Налайх, 2-р хороо, , 57 байр, 1 тоот хаягт оршин суух УД79052500 регистрийн дугаартай, Боржигон овогт Бямбадорж-н **ОТГОНЭРДЭНЭ**
**Худалдан авагч:** Улаанбаатар, Налайх, 2-р хороо, , 49 байр, 3 тоот хаягт оршин суух УЕ87091476 регистрийн дугаартай, Хондого овогт Даваадорж-н **БАТЭРДЭНЭ** бид харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

## Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээний зорилго худалдагч нь худалдан авагч үнийг төлөхөөс өмнө үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх, худалдан авагч нь үнийг гэрээнд заасны дагуу тодорхой цаг хугацааны дараа хэсэгчлэн буюу бүрэн, эсхүл тодорхой цаг хугацааны туршид хэсэгчлэн төлөхтэй холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулахад оршино.
1.2 Талууд гэрээний үүргээ шударгаар, бодитоор, зохих ёсоор биелүүлнэ.
1.3 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг хуулиар зохицуулна.

## Хоёр. Гэрээний зүйл

2.1 Үл хөдлөх эд хөрөнгийн талаарх мэдээлэл:

| | |
|---|---|
| Улсын бүртгэлийн дугаар, Гэрчилгээний дугаар | Ү-2207001496, 000663189 |
| Хаяг, Хэмжээ | Налайх дүүрэг 2-р хороо,50-24 тоот, 29мкв,2 өрөө |
| Зориулалт | Орон сууц |

## Гурав. Гол нөхцөл

3.1 **Гэрээний зүйлийн үнэ:** Үл хөдлөх эд хөрөнгийг худалдагч тал худалдан авагч талд 45,000,000.00 Дөчин таван сая төгрөг худалдахаар тохиролцов.
3.2 **Төлбөрийн хэмжээ, төлөх нөхцөл:** Хавсралт Урьдчилгээ 22.500.000 төгрөгийг ДҮТ ТӨХХК-ниас Т.Ганболдын Хаан банкны 5749380096 тоот дэнсруу шилжүүлнэ,Үлдэгдэл 22.500.000 төгрөгийг 2023.2.10 ны өдөр төлж барагдуулах бөгөөд 100 хувь төлж дууссаны дараа гэрчилгээг ДЛ.Бат-Эрдэнэ-ий нэр дээр нь шилжүүлж өгөхөөр тохирлцсон болно.-д заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлнө.
3.3 **Үл хөдлөх эд хөрөнгийг хүлээлгэн өгөх хугацаа:** 2023.02.10
3.4 **Гэрээг улсын бүртгэлд бүртгүүлэх:** төлбөрийг бүрэн төлж дууссан тохиолдолд бүртгүүлнэ. Тийм
3.5 **Төлбөрийг бүрэн төлөх хүртэлх хугацаанд хүү тооцох эсэх:** Тооцохгүй.
3.6 **Үүргийн гүйцэтгэлийг хангах арга:** Байхгүй.

## Дөрөв. Талуудын эрх, үүрэг

4.1 Худалдагч нь эрхийн зөрчилгүй, биет байдлын доголдолгүй гэрээнд заасан зориулалтаар ашиглах бүрэн боломжтой, гэрээ байгуулах үед өмчлөлийн ямар нэгэн маргаангүй үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх үүрэгтэй.
4.2 Худалдагч тал худалдаж байгаа үл хөдлөх эд хөрөнгийн чанар, ашиглах хугацаанд гарсан элэгдэл болон доголдлын талаар холбогдох мэдээллийг худалдан авагч талд өгөх үүрэгтэй.
4.3 Худалдан авагч нь худалдан авч буй үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой мэдээлэл авах эрхтэй бөгөөд худалдагчийн өмчлөл, эзэмшлийнх мөн болохыг шалгаж авах үүрэгтэй.
4.4 Худалдагч үл хөдлөх эд хөрөнгийг худалдахаар харилцан тохиролцсон төлбөрийг худалдан авагчаас шаардах эрхтэй.

2022-02-07

BZRJ-ODPA-VD47

4.5 Худалдагч үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх үед түүний доголдлыг мэдсээр байж нуун дарагдуулсан бол худалдан авагч тал шаардлага гаргах эрхтэй.
4.6 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ худалдан авагч биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол худалдагч гэрээнээс татгалзаж, үл хөдлөх эд хөрөнгөө буцаан авч, учирсан хохирол, зардлаа нэхэмжлэх эрхтэй.
4.7 Худалдаж буй үл хөдлөх эд хөрөнгийн эзэмшил худалдан авагчид шилжихээс өмнөх ашиглалтын зардал /ус, дулаан, цахилгаан, СӨХ, кабель, интернетийн төлбөр гэх мэт/ болон татвар, хураамжийг худалдагч тал төлөх үүрэгтэй.
4.8 Худалдан авагч төлбөрийг бүрэн төлж дууссаны дараа талууд төлбөр бүрэн төлөгдсөн тухай баримт бичиг үйлдэж гэрээнд хавсаргах бөгөөд худалдан авагч нь үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхээ хууль тогтоомжид заасанаар улсын бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй.
Тийм

**Тав. Хариуцлага**

5.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ худалдан авагч биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс худалдагчид учирсан хохирол, зардлыг худалдан авагч хариуцна.
5.2 Үл хөдлөх эд хөрөнгийн доголдолтой холбогдуулан худалдагч, худалдан авагчийн аль нь ч гэрээг цуцлах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд худалдагч нь худалдан авагчид учирсан хохирол, зардлыг хариуцна.
5.3 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг зөрчсөн тал хариуцна.
Тийм

**Зургаа. Бусад нөхцөл**

6.1 Энэхүү гэрээг нотариатаар гэрчлүүлэн, улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох бөгөөд Иргэний хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-д зааснаар өмчлөх эрх худалдан авагч талд үүсэж, худалдагч талын өмчлөх эрх дуусгавар болно.
6.2 Талууд гэрээнд нэмэлт. өөрчлөлт оруулахыг хүсвэл энэ тухай саналаа нөгөө талдаа мэдэгдэж, харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ байгуулж гарын үсэг зурах бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
6.3 Үл хөдлөх эд хөрөнгийг борлуулсны орлогын албан татварыг худалдагч тал хариуцна.
6.4 Гэрээг нотариатаар гэрчлүүлэх, улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдсон зардлыг худалдан авагч тал хариуцна.
6.5 Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарвал талууд харилцан зөвшилцөх бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.
Тийм

ХЗДХ-ийн сайдын 2011 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 123 тоот тушаалаар батлагдсан "Нотариатын үйлчилгээний хөлс, зардал"-ын дагуу 50.000.00 төгрөг хураав. Гэрээг 3 хувь үйлдэв.**Энэхүү гэрээнд оролцогч талуудад гэрээний агуулга, хууль зүйн үр дагаврыг нотариатч зөвлөсөн болно. Гэрээг тэгш эрхийн үндсэн дээр байгуулж, гэрээний агуулга, үр дагаврыг ойлгож, уншиж танилцсан бөгөөд бусдын дарамт шахалт, бусад хүчин зүйлд авталгүйгээр, бидний хүсэл зоригт бүрэн нийцсэн тул** нотариатчийн ажлын **байранд, Х.МАЯРАГУЛЬ түүний дэргэд гарын үсэг зурсан болно.**

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ХУДАЛДАГЧ:**

**Б.ОТГОНЭРДЭНЭ** 96005989

**ХУДАЛДАН АВАГЧ:**

**Д.БАТЭРДЭНЭ** 99070687

2022-02-07 ... өдөр ... Бүртгэлийн № ...
Нийслэлийн ... нотариатч
Х.Майрагуль ...
үнэн зөвийг гэрчлэв
2022-02-07
Нотариатч ...

3ZRI-ODPA-VD47